

**“Эй Эл Жи Ти” ХХК-ИЙН УВС АЙМГИЙН НАРАНБУЛАГ СУМЫН
НУТАГТ ОРШИХ “ХАРГАНАТ”-ЫН ТӨМРИЙН ОРДЫН
ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

/РД- 5130622/
MV-013766

АГУУЛГА

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	
1.1 Төслийн байршил	4
1.2 Ордын нөөц, тусгай зөвшөөрөл	5
1.3 Төслийн хүчин чадал	5
1.4 Ил уурхайн ажиллах горим	8
1.5 Ашиглалтын систем	9
1.6 Өрөмдлөгийн ажил	10
1.7 Тэсэлгээ,тэсрэх материалын агуулах	11
1.8 Ил уурхайн тээвэр	11
1.9 Авто зам	11
1.10 Гадаад тээвэр	12
1.11 Овоолго	13
1.12 Хүдэр баяжуулах технологи	13
1.13 Ил уурхайн технологийн усан хангамж	14
1.14 Уурхайн унд ахуйн хэрэгцээний усан хангамж, хэрэглээний тооцоо	14
1.15 Цахилгаан хангамж	15
1.16 Уурхайн дэд бүтэц	15
1.17 Уурхайн эдийн засгийн үзүүлэлт	15
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БО,НЭЗ ТАНИЛЦУУЛГА	17
3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ	21
4. БОМТ-НИЙ ТУХАЙН ЖИЛИЙН ГОЛ ЗОРИЛТ	26
4.1 Зорилго, хамрах хүрээ	26
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	
1. Агаар	27
2. Ус	28
3. Хөрс	29
4. Ургамал	30
5. Амьтан	31
6. Түүх	31
6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	32
7. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	32
8. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨ	34
9. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨ	35

10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	37
11. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	39
12. БОМТ-НИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОЛОН НИЙТЭД ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ	40

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

<i>Хүснэгт 1. Төслийн талбайн мэдээлэл</i>	<i>4</i>
<i>Хүснэгт 2. ТЭЗҮ-ийн ерөнхий мэдээлэл</i>	<i>5</i>
<i>Хүснэгт 3. Эдийн засгийн үзүүлэлтүүд</i>	<i>6</i>
<i>Хүснэгт 4. Уурхайн баяжмал гаргалтын хэмжээ</i>	<i>7</i>
<i>Хүснэгт 5. Уурхайн гадаргуугийн эдэлбэр газрын хэмжээ</i>	<i>8</i>
<i>Хүснэгт 6. Ил уурхайн үндсэн хэмжээсүүд</i>	<i>10</i>
<i>Хүснэгт 7. Ил уурхайн ажлын төлөвлөгөө</i>	<i>10</i>
<i>Хүснэгт 8. Уурхайн баяжмал гаргалтын хэмжээ</i>	<i>13</i>
<i>Хүснэгт 9. Овоолгын үндсэн хэмжээсүүд</i>	<i>13</i>
<i>Хүснэгт 10. Усалгаанд зарцуулах усны тооцоо</i>	<i>14</i>
<i>Хүснэгт 11. Төслийн унд ахуйн усны хэрэгцээ</i>	<i>15</i>
<i>Хүснэгт 12. Нийт усны хэрэглээ</i>	<i>15</i>
<i>Хүснэгт 13. Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөлийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим</i>	<i>24</i>
<i>Хүснэгт 14. Сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулах, арилгах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ</i>	<i>30</i>
<i>Хүснэгт 15. Дүйцүүлэн хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ</i>	<i>36</i>
<i>Хүснэгт 16. Осол эрсдэлийн менежмент төлөвлөгөө</i>	<i>37</i>
<i>Хүснэгт 17. Хог хаягдлын менежмент төлөвлөгөө</i>	<i>39</i>
<i>Хүснэгт 18. ОХШХөтөлбөр</i>	<i>40</i>
<i>Хүснэгт 19. БОМТ-г олон нийтэд тайлагнах хуваарь</i>	<i>44</i>

ЗУРГИЙН ЖАГСААЛТ


<i>Зураг 1. Төслийн байршил</i>	<i>4</i>
<i>Зураг 2. Уурхайн ерөнхий дэвсгэр зураг</i>	<i>9</i>
<i>Зураг 3. Гадаад тээврийн маршрут</i>	<i>13</i>
<i>Зураг 4. Төслийн талбайн нөлөөлөл буурах зэрэг</i>	<i>31</i>

1.ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн байршил

Харганатын төмрийн ордын талбайн засаг захиргааны харьяаллын хувьд Увс аймгийн Наранбулаг сумын нутагт (М-46-89) байрладаг ба Улаанбаатар хотоос баруун тийш 1300 км, Увс аймгийн төв Улаангом хотоос зүүн урагшаа 50 км, Наранбулаг сумын төвөөс баруун тийшээ 50 км зайд тус тус алслагдсан байдаг.

Зураг 1. Төслийн байршил



Хүснэгт 1. Тусгай зөвшөөрлийн талбайн мэдээлэл

Тусгай зөвшөөрөл	Олгогдсон (он-сар-өдөр)	Хугацаа (жил)	Цэгийн дугаар	Уртраг (град, мин, сек)	Өргөрөг (град, мин, сек)
Газрын солбицол нь: L-49-60					
MV-013766 (111.52га)	2014-11-17	30	1	92° 11' 39.19"	49° 36' 51.79"
			2	92° 10' 39.19"	49° 36' 51.79"
			3	92° 10' 39.19"	49° 37' 21.78"
			4	92° 11' 39.19"	49° 37' 21.78"

1.2 Ордын нөөц, тусгай зөвшөөрөл

2010 онд “Эй Эл Жи Ти” ХХК нь геофизикийн судалгааны ажлын үр дүнг үндэслэн өөрийн хөрөнгөөр гүйцээх хайгуулын ажлыг геологич Б.Дакибас, Х.Шаует нарын удирдлагаар хийж гүйцэтгэсэн байна. Энэ ажлын хүрээнд эрлийн маршрут (20т.км), гидрогеологийн судалгаа төрөл бүрийн сорьцлолт хийж, хайгуулын 9 шугамаар 15-45м гүнтэй 30 цооног өрөмдсөн байна. Харганатын ордын хүдрийн ордын нөөцийн тодотгол тооцоог 2017 онд ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн В+С зэргээр нийт 15.02 сая.тн төмрийн хүдрийн нөөцийг бүртгүүлсэн.

1.3 Төслийн хүчин чадал

Энэхүү уурхай нь жилд 750.0 мян.тн хүдэр олборлох хүчин чадалтай бөгөөд нийт 20 жилийн хугацаанд ашиглагдана. Ил уурхайн ажиллах эхний 10 жилийн тооцоог ТЭЗҮ-д тусгасан байна.

Хүснэгт 2. Техник эдийн засгийн үндэслэлийн ерөнхий мэдээлэл

№	Үзүүлэлтүүд	Тодорхойлолтууд	
1	Аж ахуйн нэгжийн нэр	“Эй Эл Жи Ти” ХХК	
2	Улсын бүртгэлийн дугаар	9011002117	
3	Уурхайн нэр	Харганатын төмрийн хүдрийн уурхай	
4	Ордын нэр ба тусгай зөвшөөрлийн дугаар	Харганатын төмрийн хүдрийн орд MV-013766	
5	Батлагдсан геологийн нөөц	Хүдэр	Металл /Fe/
		В=10821819тн	В=4559864тн
		С=4206587.7тн	С=1169164.4тн
		В+С=15028406.7тн	В+С=5729028.4тн
6	Ил уурхайн хүрэн дэх геологийн нөөц	В+С=14935465тн хүдэр	
7	Ил урхайн хүрэн дэх үйлдвэрлэлийн нөөц	В+С=14405858тн хүдэр	
8	Ашиглах арга ба хугацаа	Ил аргаар 20 жил	
9	Ашиглалтын систем	Ил уурхай: Тээвэртэй ашиглалтын систем	
10	Жилийн хүчин чадал	Ил уурхай	
		- Хүдэр олборлолт -750.0 мян.тн	
		- Хөрс хуулалт -13.29-56.26 мян.м ³	
		Баяжуулах үйлдвэр	
		- Хүдэр боловсруулалт -750.0 мян.тн	

		- Төмрийн баяжмал гаргалт-402.62 мян.тн
11	Ил уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүд	<ul style="list-style-type: none"> - 1.2 м³-ийн утгуурын багтаамжтай CAT-320D маркийн урвуу утгуурт экскаватор - 81 кВт-ийн хүчин чадалтай SHANTUI фирмийн TY-120 маркийн бульдозер - 45 тоннын даацтай SINOTRUK HOWO автосамосвалууд - 140-160 мм-ийн диаметртэй JK358H маркийн өрмийн машинууд - 116 кВт-ийн хүчин чадалтай LUIGONG фирмийн CLG416 маркийг автогрейдер - 3 м³-н шанаганы багтаамжтай ZL-50 маркийн утгуурт ачигчууд зэрэг болно.
12	Уурхайн ёроолын түвшин	Ил уурхай 1450 м
13	Ажлын доголын өндөр	<ul style="list-style-type: none"> - Хөрс хуулалт 5м - Хүдэр олборлолт 5м
14	Доголын налууугийн өнцөг	65°
15	Ажлын талбайн өргөн	30м
16	Замын налуу	80°/00
17	Цахилгаан хангамж	Уурхай хүртэл 3км 35кВ-ын өндөр хүчдэл татах. 630 кВА чадалтай ТМН-630 маркийн 35/0.4кВ-ын ерөнхий бууруулах дэд станц
18	Засвар үйлчилгээ	Засвар механикийн цех

Хүснэгт 3. Эдийн засгийн үзүүлэлтүүд

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Нийт /10 жилд/
1	Уулын цул	мян.м ³	1804.55
2	Хөрс хуулалт	мян.м ³	306.07
3	Хүдэр олборлолт	мян.тн	7357.49
4	Бүтээгдэхүүн гаргалт /төмрийн баяжмал/	мян.тн	4026.2
5	Бүтээгдэхүүн борлуулах үнэ	мян.төг/тн	130.12
6	Борлуулалтын орлого	сая.төг	523869.01
7	Төслийн нийт хөрөнгө оруулалт	сая.төг	14066.38
8	1тн баяжмалын өөрийн өртөг	мян.төг/тн	108.05
9	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	сая.төг	29554.12
10	Татварын өмнөх ашиг	сая.төг	88820.33

11	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар	сая.төг	17705.08	
12	Цэвэр ашиг	сая.төг	71115.25	
13	Төслийн шалгуур үзүүлэлтүүд:	Хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа	1.8	0.5
		Төслийн өнөөгийн цэвэр үнэ цэнэ NPV 10%	36973.32	47762.26
		Төслийн өнөөгийн цэвэр үнэ цэнэ NPV 12%	32666.07	43572.54
		Өгөөжийн дотоод норм – (IRR)	55%	159%
14	Шинээр бий болох ажлын байр	хүн	72	
15	Ажиллагсадын дундаж цалин	мян.төг	1886.67	
16	Улсын төсөвт төлөх татвар төлбөр	сая.төг	43398.27	
17	Орон нутгийн төсөвт төлөх татвар төлбөр	сая.төг	12994.1	
18	Татвар, төлбөрийн борлуулалтын орлогод эзлэх хувь	%	10.8	

Ил уурхайн баяжуулалтын хүчин чадлыг жилд 374-441.0 мян.тн хүдэр олборлохоор ашиглахар ТЭЗҮ-д тусгасан байна. Ил уурхайн ажиллах эхний 10 жилийн тооцоог хийж энэхүү төсөлд тусгасан байна.

Хүснэгт 4. Уурхайн баяжмал гаргалтын хэмжээ

№	Ашиглалтын жилүүд	Тээвэрлэх баяжмалын хэмжээ, мян.тн
1	I жил	374.0
2	II жил	441.3
3	III жил	418.2
4	IV жил	416.7
5	V жил	406.4
6	VI жил	404.0
7	VII жил	399.9
8	VIII жил	393.9
9	IX жил	389.6
10	X жил	382.2
11	Дүн	4026.2
12	Дундаж	402.62

Уурхайн байршлын ерөнхий төлөвлөлтийг ордын нөөц ашиглалтын хэтийн төлөв ажиллагсадын тосгоны амьдрах эрүүл ахуйн нөхцөл, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөлийг багасгах зэрэг нөхцлүүдийг үндэслэн гаргасан байна.

Уг төсөлд эдгээр барилга байгууламж болон үйлдвэрлэлийн зориулалттай объектуудыг сэндвичин угсармал хавтангаар барьж байгуулахаар төлөвлөсөн байна.

Хүснэгт 5. Уурхайн гадаргуугийн эдэлбэр газрын хэмжээ


№	Байгууламжуудын нэр	Эзлэх талбайн хэмжээ, га	Ил уурхайгаас алслагдсан зай, м
1	Ил уурхай	16.5	
2	Хөрсний гадаад овоолго	9.5	5-10
3	Үйлдвэрлэлийн талбай	1.7	500-600
4	Тосгон, агуулах, бусад	0.8	800
5	Нийт авто зам		5км
6	ШТМ	1.3	400

1.4 Ил уурхайн ажиллах горим

Уурхайн ажиллах горимыг уурхайн хүчин чадал, жилд гүйцэтгэх уулын ажлын хэмжээнээс хамааруулан жилийн турш, хоногийн 12 цагийн үргэлжлэлтэй 2 ээлжээр ажиллахаар төсөлд тусгасан. Уурхайн жилд ажиллах хоногийг дараах байдлаар үзүүлбэл:

- Жилийн нийт хоног 365 хоног
- Үндэсний баяр, ёслолын хоног 9 хоног
- Өвлийн улирлын сул зогсолт 70 хоног
- Засвар үйлчилгээ 28 хоног
- Цаг агаарын нөхцөлийг тооцсон хоног 18 хоног
- Уурхайн жилд ажиллах хоног 240 хоног
- Хоногт ажиллах ээлжийн тоо 2 ээлж
- Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг

Зураг 2. Уурхайн ерөнхий дэвсгэр зураг



1.5 Ашиглалтын систем

Харганатын төмрийн хүдрийн ил уурхайд хөрс хуулалт, болон хүдэр олборлолтын ажлыг өрөмдлөг тэсэлгээ, экскавацлалт, автотээвэр гадаад овоолго гэсэн ил уурхайн ашиглалтын системээр гүйцэтгэнэ. Тус ордын хүдрийг нарийвчилсан хайгуулын ажлын үр дүнд тодорхойлогдсон +990 метрийн түвшин хүртэл ил уурхайгаар хүдрийн биетийн уналын дагуу дээрээсээ доош гэсэн ерөнхий чиглэлтэй, хүдрийн биетийн суналын дагуу уулын ажлын ахилттайгаар гүйцэтгэнэ. Хөрс хуулалт болон хүдэр олборлолтын ажлыг урьдчилан өрөмдлөг тэсэлгээний ажлын тусламжтайгаар сийрэгжүүлэлтийн ажлыг хийсний дараа экскаваторын тусламжтайгаар автосамосвалд ачин, хөрс хуулалтын чулуулгийг ил уурхайн гадаад овоолгод, хүдрийг баяжуулах үйлдвэрийн дэргэдэх хүдрийн агуулах хүртэл тээвэрлэн байрлуулна.

Экскаваторуудын техникийн үзүүлэлтүүд болон хүдэр, хөрсний чулуулгийн физик механикийн шинж чанаруудаас хамааруулан хөрс хуулалтын болон хүдэр олборлолтын ажлын доголын өндрийг 5 метр байхаар тооцоолсон байна.

УВС АЙМГИЙН НАРАНБУЛАГ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХАРГАНАТ”-ЫН ТӨМРИЙН ОРДЫН
ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
Хүснэгт 6. Ил уурхайн үндсэн хэмжээсүүд

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Ил уурхай
1	Ил уурхайн гүн	М	70
2	Ил уурхайн амсрын урт	М	1000
3	Ил уурхайн амсрын өргөн	М	230
4	Ил уурхайн хажуугийн өнцөг	Градус	38/21-60/
5	Хөрс хуулалтын ажлын доголын өндөр	М	5-10
6	Хүдэр олборлолтын ажлын доголын өндөр	М	5
7	Доголын налуугийн хэмжээ	Градус	60
8	Ажлын бус доголын аюулгүйн өргөн	М	1.5
9	Ажлын доголын аюулгүйн өргөн	М	1.5
10	Авто замын өргөн	М	8
11	Авто замын налуугийн хэмжээ	Промиль	80
12	Ил уурхайн улны хэсгийн хамгийн бага өргөн	М	10
13	Ил уурхайн улны хэсгийн хамгийн бага урт	М	47
14	Ажлын талбайн өргөн	М	20-30

Хүснэгт 7. Ил уурхайн уулын ажлын календарь төлөвлөгөө

№	Ашиглалтын жилүүд	Уулын цул	Хүдэр			Агуулга	Металл	Хөрс хуулалт	Хөрс хуулалтын коэффициент	
			мян.м ³	мян.м ³	мян.тн				%	мян.тн
1	I жил	148.15	123.73	607.49	41.69	253.29	24.42	0.04	0.20	
2	II жил	166.04	152.75	750.0	40.39	302.95	13.29	0.02	0.09	
3	III жил	172.26	152.75	750.0	38.92	291.92	19.51	0.03	0.13	
4	IV жил	170.65	152.75	750.0	38.82	291.14	17.90	0.02	0.12	
5	V жил	169.93	152.75	750.0	38.16	286.17	17.18	0.02	0.11	
6	VI жил	170.64	152.75	750.0	38.01	285.09	17.89	0.02	0.12	
7	VII жил	185.38	152.75	750.0	37.75	283.14	32.63	0.04	0.21	
8	VIII жил	209.01	152.75	750.0	37.37	280.31	56.26	0.08	0.37	
9	IX жил	226.81	152.75	750.0	37.09	278.18	74.06	0.10	0.48	
10	X жил	185.68	152.75	750.0	36.62	274.62	32.93	0.04	0.22	
11	Дүн	1804.56	1498.47	7357.49	38.42	2,826.81	306.09	0.04	0.20	

1.6 Өрөмдлөгийн ажил

Өрмийн төхөөрөмжийн ажиллах талбайг засаж тэгшлэх, бэлтгэх төхөөрөмж ба туслах тоноглолыг ажилд бэлтгэх, цахилгаан эрчим хүч, өрмийн багаж төхөөрөмж бусад материалаар хангах, өрөмдсөн цооногуудыг эвдрэлтээс хамгаалах, бүртгэх, хэмжих төхөөрөмжүүд зөөвөр нүүдэл, засварын ажлын өөрчлөлт зэрэг олон туслах ажлууд хийгдэнэ. Доголын талбайг өрөмдлөгт бэлтгэхдээ талбайд буй саад болох тоног төхөөрөмж бусад зүйлийг зайлуулах тэгшлэх, зам засах зэрэг ажлыг голдуу бульдозер хэрэглэж гүйцэтгэнэ. Засаж бэлдсэн талбайд маркшейдерийн хэмжилтээр цооног байрлах тэмдэглэгээг хийх ба шахсан хий усаар хангах, өрөмдөх

төхөөрөмжөө байрлуулж ажилд бэлтгэх ажиллагааг хэрэгжүүлнэ. Өрөмдлөгийн ажлын төслөөр (паспорт) цооног бүрийн байршил, гүний хэмжээг тогтооно. Хяналтын хэмжилтээр ажлын хэрэгжилтийг тодорхойлох ба өрөмдөх цооног хоорондын зай гүний зөрүү нь 0.3 м-ээс хэтрэхгүй байх ёстой. Цооног янз бүрийн учир шалтгаанаар нурж гүн нь хорогдох, цасаар дүүрэх, ус тогтох мөстөх зэрэг тохиолдолд дахиж өрөмдлөг хийж засварлана.

1.7 Тэсэлгээ, тэсрэх материалын агуулах

“Тус ил уурхайн тэсрэх бодисын болон тэсэлгээний хэрэгслийн агуулах нь уурхайн зүүн хойд талд аюулгүй зайд байрлана. Тэсрэх бодис хадгалах 40 тоннын багтаамжтай 2 ширхэг контейнер, тэсэлгээний хэрэгсэл хадгалах зориулалт бүхий 40 тоннын контейнер агуулах тус тус байна. Тэсрэх материалын агуулахыг зэвсэглэсэн гэрээт харуул хамгаалалтын ажилтнууд хамгаална” гэж ТЭЗҮ-д тусгасан. Одоогийн байдлаар манай компани гэрээт компаниар тэсэлгээний ажлыг гүйцэтгүүлж байна.

1.8 Ил уурхайн тээвэр

Уурхайн дотоод тээвэр

Ил уурхайн технологийн авто тээвэр нь уурхайн хөрөнгө оруулалтын 50-60% ашиглалтын зардлын 70 хүртэлх хувийг эзэлдэг үйлдвэрлэлийн хөрөнгө, хөдөлмөр зарцуулалт хамгийн ихтэй үндсэн процессуудын нэг юм. Энэхүү ил уурхайд 15-20 тн-н даацтай автосамосвалуудыг ашиглахаар ТЭЗҮ-д тусгасан байна.


1.9 Авто зам

Уурхайн авто замыг байгуулахдаа хүдэр олборлолтын болон хөрс хуулалтын ажлын доголудаас хүдэр хадгалах агуулах хүртэлх, хөрс хуулалтын чулуулгийг гадаад овоолго хүртэл тээвэрлэх зай нь хамгийн бага байхаар тооцсон байна. Замын үйлчилгээ нь улирлын байдлаас хамаарч автосамосвалыг аюулгүй бүтээлтэй ашиглах зорилгын үүднээс өдөр бүр хийгдэнэ. Тухайлбал зуны улиралд ус зайлуулах суваг төхөөрөмжийг байнга хянах, цэвэрлэх, тоосжилтыг багасгах арга хэмжээ авах, зам цэвэрлэх гэх мэт. Дунд засвар нь 1-2 жилд нэг удаа хийгдэх ба энэ хугацаанд элэгдсэн элэгдэл, эвдрэлүүдийг сэргээн засварлана. Ил уурхайн дотоод тээврийн болон гадаад тээврийн замын цэвэрлэгээ засварын ажилд бульдозер, автогрейдерийг хэрэглэхээр ТЭЗҮ-д тусгасан байна.

1.10 Гадаад тээвэр

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018.04.30-ны өдрийн 84 тоот тушаалаар төмрийн хүдрийн тээвэрлэлтийн маршрутыг Увс аймгийн Наранбулаг сумын Харганатын ордоос Ховд аймгийн Булган сумын Цоохор нуур хүртэл чиглэлээр баталсан. Харганатын уурхайгаас Ховд аймгийн Мянгад сум хүртэл 170 км сайжруулсан шороон замаар, Мянгад сумаас хилийн боомт хүртэл 505 км хатуу хучилттай замаар, нийтдээ 675 км замаар төмрийн хүдэр тээвэрлэх бөгөөд энэ нь Монгол Улсад хамгийн урт замын тээвэрлэлт байна. Дээрх тушаалын дагуу “Увс-АЗЗА” ТӨХК-тай гэрээг байгуулж хамтран ажиллахаас гадна манай компани Харганат-Өлгий-Мянгад чиглэлийн замын их болон дунд засварын ажлыг өөрийн хүч, хөрөнгөөр хийж гүйцэтгэж байна. Мөн тоос тоосонцор үүсэхээс сэргийлж замыг тогтмол усалж байна.

Зураг 3. Гадаад тээврийн замын маршрут



1.11 Овоолго

Тус ордын хөрс хуулалтанд тээвэртэй ашиглалтын систем хэрэглэх бөгөөд ашиглагдсан хоосон орон зайд байнгын уулын ажил явагдаж хөрсийг гадаад овоолгод байршуулна. Хөрсний гадаад овоолго ил уурхайн баруун хойд, зүүн урд талд 20-35м зайд байрлана. Хөрсний гадаад овоолгын дундаж өндөр 20 м, эзлэхүүн эцсийн байдлаар 1.0 сая.м³ байна.

Хүснэгт 9. Овоолгын үндсэн үзүүлэлтүүд

№	Овоолгын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ 10 жил	Тоо хэмжээ 20 жил
1	Үржил шимт хөрсний овоолго	мян.м ³	20.3 /0.87га/	33 /1.38га/
2	Хөрсний гадаад овоолго	сая.м ³	0.3 /6.2га/	1.0 /15.4га/
3	Овоолгын өндөр /дунджаар/	М	0-25	7-32
4	Овоолгын налуу	градус	38	38

1.12 Хүдэр баяжуулах технологи

Харганатын төмрийн хүдрийг хуурай соронзон аргаар баяжуулах технологийг сонгосон байна.

Технологийн ерөнхий шийдлүүд

- Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал
 - 750.0 мян.тн/жил
 - 3125 тн/хоног
 - 162.8 тн/цаг
 - 240 хоног/жил
 - 5760 цаг/жил
- Анхдагч хүдрийн ширхэглэл - 0-600 мм
- Анхдагч хүдэр дэх төмрийн агуулга - 36.6-41.7%
- Баяжмал дахь төмрийн агуулга - 58.0-59.8%
- Баяжмалын гарц - 50.0-60.0%
- Баяжмалын металл авалт - 83.0-88.0%
- Хүдэр бэлтгэх технологи - 3 шатны бутлалт, 1 шатны хяналтын шигшилт
- Хүдэр баяжуулах технологи - Үндсэн болон 1 шатны цэвэрлэгээний хуурай соронзон баяжуулалт
- Хаягдлын хэлбэр - Хуурай
- Хаягдал дахь төмрийн агуулга - 12.6-12.7%

1.13 Ил уурхайн технологийн усан хангамж

Уурхай нь технологийн буюу үйлдвэрт ус ашиглахгүй. Уурхайн усны хэрэглэгч нь уурхайн зам, талбайн усалгаа болон техник, тоног төхөөрөмжийн усны хэрэглээ байна. Уурхайн зам усалгааны усны хэрэглээг доорх хүснэгтэд үзүүлэв. Уурхайд нийт 5 км урт 8 м өргөн зам байна. Нийт талбайн хэмжээ нь: $5000 \text{ м} * 8 \text{ м} = 40000 \text{ м}^2$ буюу 4 га. Зам талбайн усалгааны норм м^2 нь 2 л (БОНХАЖЯ-ны сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалаар батласан нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны нормын 13 дугаар хавсралт). Хоногт $40000 \text{ м}^2 * 2 \text{ л} = 80000 \text{ л}$ буюу 80 м^3 ус 1 өдөрт зарцуулна /өдөрт 1 удаа усална/. Уурхайн ашиглалтын явцад 1 жилд $80 \text{ м}^3 * 240 \text{ хоног} = 19200 \text{ м}^3$ ус зам усалгаанд зарцуулна.

Хүснэгт 10. Усалгаанд зарцуулах усны тооцоо

№	Үзүүлэлтүүд	Хоногт	Нэг жилд	5 жилд
	Хэмжих нэгж	м^3	Мян. м^3	Мян. м^3
1	Зам, талбайн услах усны хэрэглээ	80	19.2	96.0
2	Өрмийн машин услах усны Хэрэглээ	20	4.8	24.0
	Нийт	100	24	120

Уурхайн зам усалгаа болон өрмийн машины усалгаанд жилд 24 мян. м^3 , нийт таван жилд 120 мян. м^3 ус хэрэглэхээр байна.

1.14 Уурхайн унд ахуйн хэрэглээний усан хангамж, хэрэглээний тооцоо

Харганатын төмрийн хүдрийн уурхай жилд 240 хоног ажиллах ба 66 хүн ажиллан гэж ТЭЗҮ-д тусгажээ. Уурхайн унд ахуйн усны хэрэглээг одоогоор хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа БОНХАЖЯ-ны сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалаар батласан нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны нормын 12 дугаар хавсралтыг үндэслэж тооцоход 1 хүн хоногт 150 л ус хэрэглэнэ.

Хүснэгт 11. Төслийн унд, ахуйн усны хэрэглээ

№	Үзүүлэлтүүд	Хоногт	Нэг жилд	5 жилд
	Хэмжих нэгж	м^3	Мян. м^3	Мян. м^3
1	Нийт 66 хүн	9900	2376.0	11 880.0
	Нийт	9900	2376.0	11 880.0

Унд ахуйн хэрэгцээт усыг уурхайн талбайд байрлах гүний худгаас хангана.

Хүснэгт 12. Нийт усны хэрэглээ

№	Үзүүлэлтүүд	Хоногт	Нэг жилд	5 жилд
	Хэмжих нэгж	Мян.м ³	Мян.м ³	Мян.м ³
1	Зам, талбай услах усны хэрэглээ	0.1	24	120
2	Унд ахуйн усны хэрэглээ	9.9	2376.0	11 880.0
Нийт		10.0	2400	12000

Харганатын төмрийн хүдрийн уурхайд жилийн хугацаанд 2400.0 мян.м³, нийт 5 жилийн хугацаанд 12000.0 мян.м³ ус хэрэглэхээр байна.

1.15 Цахилгаан хангамж

Тус ордын уурхай болон баяжуулах үйлдвэрийн цахилгаан хэрэглэгчдийг Увс аймгийн төв Улаангом-Тариалан сум-Наранбулаг сум руу татах 35кВ-ын өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам ордын дэргэдүүр өнгөрөх бөгөөд уурхай хүртэл 13 км 35кВ-ын цахилгааны шугам татаж эрчим хүчээр хангана.

1.16 Уурхайн дэд бүтэц

Харганатын төмрийн хүдрийн ордыг ил уурхайн барилга байгууламжийг үйлдвэрлэлийн ба ахуйн зориулалтаар тус тусад нь барьж байгуулна. Уурхайд дунджаар 66 хүн ажиллана. Уурхайн ажиллагсдын хотхоныг уурхайн баруун урд зүгт 0.9 км зайд барьж байгуулсан. Уурхайн хотхонд уурхайн захиргааны байр хоолны газар, халуун ус, ахуй үйлчилгээний байр уурын зуух, засварын газар, авто гараж, сэлбэг материалын агуулах зэрэг барилга байгууламжууд байх үйлдвэрийн барилга байгууламжууд шатах тослох болон тэсрэх материалын агуулах автомашины зогсоол зэрэг байна.

Үйлдвэрийн бүрэлдэхүүн нь тус ордоос хүдэр олборлох, боловсруулах, тээвэрлэх технологи болон түүний үйл ажиллагааг хэвийн явуулах, төлөвлөсөн хүчин чадлыг бүрэн эзэмших нөхцөл, үйл ажиллагаагаар тодорхойлогдоно. Уг төсөлд барилга байгууламж болон үйлдвэрлэлийн зориулалттай объектуудыг сэндвичин угсармал хавтангаар барьж байгуулсан.

1.17 Уурхайн эдийн засаг үзүүлэлт

Увс аймгийн Наранбулаг сумын нутаг дахь Харганатын төмрийн хүдрийн ордыг ашиглан 10 жилийн хугацаанд 7357.49 мян.тн хүдрийг ил аргаар олборлон хуурай соронзон аргаар баяжуулж нийт 2633.0 мян.тн төмрийн хүдрийг үйлдвэрлэн БНХАУ-

УВС АЙМГИЙН НАРАНБУЛАГ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХАРГАНАТ”-ЫН ТӨМРИЙН ОРДЫН ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ Д ЭКСПОРТЛОНО. УВС аймгийн Наранбулаг сумын нутагт орших Харганатын төмрийн хүдрийн ордоос олборлох төмрийн хүдрийг БНХАУ-д борлуулж байна. Тус ордын 59.8%-ийн агуулгатай төмрийн хүдрийн баяжмалын үнийг Хятадын төмрийн хүдрийн зах зээлийн судалгаа болон судлаачдын үнийн прогнозыг үндэс болгон 1 тн баяжмалын үнийг DAF Булган боомт нөхцлөөр хамгийн багаар 53 ам.доллар/тн байхаар тооцож ТЭЗҮ-ийг боловсруулсан байна.

Хөрөнгө оруулалтын зардал

Харганатын төмрийн хүдрийн ордыг “Эй Эл Жи Ти” ХХК ашиглах эрхийг авсан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ 610км зайд Ховд аймгийн Булган боомт хүртэл түрээсийн тээврээр тээвэрлэн БНХАУ-н зах зээлд борлуулна. Тус ордыг ашиглахад шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээ нь 14.06 тэрбум төгрөг болж байна.

Хүдэр олборлох, баяжуулах үйлдвэрлэлийн зардал

Үйлдвэрлэлийн зардлыг дараах зардлын элементүүдээр тооцоолов. Үүнд:

- Материалын зардал
- Түлш, шатах тослох материалын зардал
- Цалин, НДШимтгэлийн зардал
- Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал
- Сэлбэгийн зардал
- Баяжмал тээврийн зардал
- Бусад болзошгүй зардал

Үр ашгийн тооцоогоор жилд дунджаар 40.8-47.7 тэрбум төгрөгийн үйлдвэрлэл үйл ажиллагааны зардал гаргаж, 48.6-57.4 тэрбум төгрөгийн борлуулалт хийнэ. Хөрөнгө оруулалтын зардлаа 1.8 жилд бүрэн нөхнө. “Эй Эл Жи Ти” ХХК нь жил бүр 6023.1-7666.6 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллана. Мэдрэмжийн шинжилгээний дүнгээс харахад бүтээгдэхүүний зах зээлийн үнэ төслийн үнээс 18% буурахад төсөл үр ашиггүй болж, өнөөгийн цэвэр үнэ цэнэ тэглэх учир төсөл ашигтай байх үнийн доод хязгаар болно. Нийт 72 хүнийг ажлын байраар хангаж, 1 ажилтны сарын дундаж цалин 1886.67 мянган төгрөг болж байгаа нь орон нутгийн хувьд боломжтой юм. Жил бүр улс болон орон нутгийн төсөвт татвар, төлбөрүүдийн хэлбэрээр 5.0-6.1 тэрбум

УВС АЙМГИЙН НАРАНБУЛАГ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХАРГАНАТ”-ЫН ТӨМРИЙН ОРДЫН
ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
төгрөг, төслийн хугацаанд нийт дүнгээрээ 56.39 тэрбум төгрөг оруулах юм. Улс орон
нутгийн төсөвт зохих журмын дагуу төслөөс оруулах хувь нэмэр нь нийт
борлуулалтын орлогын 10.8%-тай тэнцэж байгаа юм.

Төслийн өнөөгийн цэвэр үнэ цэнэ нь цаг хугацааны хүчин зүйлийн
итгэлцүүрийг 10% байхад 36.97 тэрбум төгрөг, 15% байхад 27.19 болж байгаа ба
хөрөнгө оруулалтын зардлын өгөөжийн дотоод норм нь 55% байгаа нь төсөл
хангалттай өндөр үр ашигтай болохыг харуулж байна. Үйлдвэрлэсэн баяжмалыг
Ховд аймгийн Булган хилийн боомт хүртэл авто замаар тээвэрлэж борлуулна. Мөн
түлш, шатахуун борлуулалт, сэлбэг материал, хоол хүнсний хангамж, цахилгаан
хангамж гэх мэтчлэн бизнесийн бусад салбаруудын үйл ажиллагааг өргөжүүлэхэд
зохих хувь нэмрийг оруулахын зэрэгцээ компанид болон улсад ашигтай төсөл болж
байгаа учраас хэрэгжүүлэх нь зүйтэй. Үр ашгийн үзүүлэлтүүд өндөр байгаа учраас
төслийг хэрэгжүүлэх нь ашигтай хэмээн дүгнэж байна.

2. Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга

Уур амьсгал

Төсөл хэрэгжиж буй талбай нь Их нууруудын хотгорт оршино. Их нууруудын хотгор нь физик газар зүйн мужлалаар говийн их мужид багтах бөгөөд алтайн ар говийн их нууруудын тойрог гэж нэрлэгддэг. Энэ нутагт 7 дугаар сард жилийн хамгийн дулаан үе байх бөгөөд агаарын дундаж температур 16.6°C хүрч, цаашид 8 дугаар сараас эхлэн сарын дундаж температур алгуур буурч 10 дугаар сарын сүүлчээр уулархаг нутгаар цочир хүйтэрч 0.9°C- ээс бага болдог. Тус нутагт үнэмлэхүй хамгийн бага температур 1 дүгээр сард -49.6°C, үнэмлэхүй хамгийн их температур 7 дугаар сард +38.9°C хүрч байжээ.

Агаарын чанар

2017 оны 11 сарын эхний 10 хоногийн байдлаар Улаангом 01 харуулын хяналт шинжилгээний дүнгээс үзэхэд: Агаар дахь хүхэрлэг хийн дундаж агууламж 5 мкг/м³, хамгийн их нь 16 мкг/м³, азотын давхар ислийн дундаж агууламж 21 мкг/м³, хамгийн их нь 44 мкг/м³, угаарын хийн дундаж агууламж 187 мкг/м³, хамгийн их агууламж нь 282 мкг/м³, тоосны дундаж агууламж 79 мкг/м³, их агууламж нь 118 мкг/м³ байлаа. Агаарын чанарын стандарттай харьцуулахад агаарын чанар цэвэр байв. Тоосны агууламж 1 агаарын чанарын стандартаас давсан байна.

Гадаргын ус

Төслийн талбайгаас Увс нуур нь 46.5 км-т, Хяргас нуур нь 59.1 км-т байрлаж байна. Төслийн талбайн хэмжээнд томоохон гол, нуур байхгүй боловч булаг шанд, ерөмдмөл ба энгийн худгууд элбэг тохиолдоно. Мөн уурхайн талбайн баруун хэсэгт 2.5 км зайд 3.0 x 1.0 км хэмжээ бүхий Шар бүрд нэртэй шорвог устай нуур байгаа ба түүний эргэн тойронд давс хужиртай хэсгүүд тархсан нь ажиглагдана.

Газрын доорхи ус

Тусгай зөвшөөрлийн талбайн орчимд янз бүрийн гаралтай дөрөвдөгчийн хурдас, юрийн тунамал хурдас, силурын терриген-шохойлог чулуулаг, кембрийн бялхмал чулуулаг протерозойн хувирмал чулуулаг, янз бүрийн нас, найрлагатай гүний чулуулгууд тархсан байх ба дээрх литологи-давхарга зүйн бүх нэгжид газрын доорх ус агуулагдана.

Хөрсөн бүрхэвч

Харгантын төмрийн хүдрийн талбай нь нийт 112 га талбайг хамаарах бөгөөд Монгол орны хөрс-газарзүйн мужлалаар Говийн их мужийн Монголын өрнөд муж Увс нуурын 23-р тойргийн бүсийн хэв шинжит хөрс зонхилон тархдаг. Энэ талбайд

УВС АЙМГИЙН НАРАНБУЛАГ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХАРГАНАТ”-ЫН ТӨМРИЙН ОРДЫН ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ хотгор гүдгэрийн нөхцөл, хөрс үүсгэсэн чулуулгийн төрөл, тэдгээрийн илрэх гүн, элсжилт, ургамлын бүлгэмдлийн ялгаа зэрэг хөрс үүсвэрийн олон хүчин зүйлсийн нөлөөллөөс хамаарч уулсын бэл хормой хэсгээр сайр чулуурхаг хүрэн, цайвархүрэн, бор хөрс тархана. Хөрс нь сул шүлтлэг урвалын орчинтой, карбонатлаг, ялзмагийн агууламж бага, цахилгаан дамжуулах чанараар бага зэрэг давсжилттай, хөдөлгөөнт фосфорын хангамж бага, хөдөлгөөнт калийн хангамж бага, механик бүрэлдэхүүн элсэнцэр байна. Хөрсний үржил шимийн ерөнхий түвшин бага.

Ургамлан нөмрөг

Төслийн талбай нь Ургамал газарзүйн мужлалтаар Говийн умард цөлөрхөг хээрийн мужийн Их нууруудын хотгорын дэд мужад хамаарах бөгөөд энэ нутгийн ургамал, амьтны аймаг нь амьтны аймаг нь цөлийн ландшафтаас ялгагдах өвөрмөц онцлогтой ч цөлийн бүлгэмдэлтэй ойролцоо шинжтэй. Ургамалжилтын хувьд өндөр уулын хээртэй хосолсон бушилзат, улалжит нуга гэсэн Монгол хэвшинжит бүлгэмдэл болон бушилзат бүлгэмдэлтэй хосолсон хүйтсэг алаг өвс-ботуульт Хангайн, Монгол Алтайн, Говь-Алтайн хэв шинжит бүлгэмдэлтэй. Төслийн талбайн ойр орчимд 11 овгийн 54 зүйл ургамал тархсанаас насны бүлгээр авч үзвэл нэг наст 7 хоёр наст 1, олон наст 36, сөөг 5, заримдаг сөөгөнцөр 5 тус тус тархсан байна.

Амьтны аймаг

Монгол орны мөлхөгчдийн суурь эх сурвалжуудад (Мөнхбаяр 2010, Тэрбиш 2006) хайгуулын талбай нь гүрвэлүүдээс Цоохор хонин гүрвэл *Phrynocephalus versicolor*, Могой гүрвэл *Eremias multiocellata*, говийн гүрвэл *Eremias przewalskii*, могойнуудаас Рашааны могой *Elaphe dione*, бамбай хоншоорт могой *Gloydus halys* гэсэн зүйлүүдийн тархац нутаг болох нь тодорхой байна. 2017 оны 8 дугаар сарын судалгаагаар дээрх зүйлүүдээс цоохор хонин гүрвэл, могой гүрвэл тэмдэглэгдсэн ба цоохор хонин гүрвэл нь харьцангуй өргөн тархалттай болох нь ажиглагдсан. *Махчин шувууд*. Төслийн талбайн хэмжээнд махчин шувуудаас сохор элээ *Milvus migrans*, ойн сар *Buteo buteo*, шилийн сар *Buteo hemilasius*, цармын бүргэд *Aquila chrysaetos*, нөмрөг тас *Aegyptius monachus*, зээрд шонхор *Falco naumanni*, начин шонхор *Falco tinnunculus* 7 зүйл бүртгэгдэв. Хээрийн судалгаа хийгдсэн 2017 оны 8 дугаар сарын дунд үед хур тунадастай, салхитай бүүдрэг зэврүүн өдрүүд таарсан тул жижиг хөхтөний идэвх сул байв. Шаргал чичүүл, бозлог зурам, сохдой оготно, бор туулай, тарвага, огдой гэсэн цөөвтөр зүйл ажиглагдсан.

ТХГН, Түүх соёлын дурсгалт газар

Төслийн талбай нь Увс нуурын ай сав ТХГН-аас 44.3 км-т, Ханхөхийн нурууны ТХГН-аас 54.6 км-т, Чандмань уулын орон нутгийн тусгай хамгаалалттай газраас 41.2 км-т тус тус байрлаж байна. Соёлын өвийн тухай хуулинд “Хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгоход палеонтологийн мэргэжлийн байгууллагаар урьдчилсан хайгуул, судалгаа хийлгэж зөвшөөрөл” авах талаар заасны дагуу Эй Эл Жи Ти ХХК, гүйцэтгэгч ШУТИС, ГУУС-ийн Стратиграфи-палеонтологийн судалгааны төвийн судлаач доктор Г. Сэрсмаа, доктор Ж. Ундарьяа нарын хооронд гэрээ байгуулан 2017 рны 9-р сарын 4-ны Харганат нэртэй MV-013766 112 га ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд палеонтологийн хайгуул, тандан судалгаа хийж гүйцэтгэсэн байна. Судалгааны үр дүнд Эй Эл Жи Ти ХХК-ийн ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь палеонтологийн хайгуул, тандан судалгааны ажлаар эртний амьтан, ургамлын чулуужсан үлдвэргүй гэж үзсэн байна.

Археологийн хайгуул судалгааны ажлыг Түүх, археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Ч.Амартүвшин, Б.Бадма-Оюу, Н.Баярхүү нарын бүрэлдэхүүнтэй баг 2017 оны 10 дугаар 28-наас 10 дугаар сарын 30-ны хооронд хийж гүйцэтгэсэн байна. Тус компаний ашиглалтын талбай нь 111,52 гектар хэмжээтэй. Тус талбайд хийсэн археологийн хайгуул судалгаагаар талбайн дотор талаас түүх соёлын ямар нэг дурсгал илэрч олдоогүй болно.

Увс аймгийн Наранбулаг сумын нутаг дахь Гурван толгой хэмээх газарт орших 13766А тоот тусгай зөвшөөрөл бүхий талбайд угсаатны зүйн авран хамгаалах судалгааг хийж гүйцэтгэсэн байна. Угсаатны зүйн судалгааны явцад тус талбайд хамаарах айл өрх таараагүй боловч улирлын чанартай нутаг бууц таарч болзошгүй тул компанийн зүгээс үйл ажиллагааг явуулахдаа Соёлын өвийг хамгаалах эрх зүйн үүднээс газар ус, бэлчээрийн хадгалалт хамгаалалтанд анхаарал тавин ажиллаж байна.

Нийгэм, эдийн засаг

Увс аймаг 69.6 мян.кв.км нутагдэвсгэртэй. Увс аймаг нь Улаанбаатар хотоос 1417 км алслагдсан. Наранбулаг сумын нутаг нь зүүн талаараа Малчин өмнө талаараа Завхан, баруун талаараа Өлгий, баруун хойд, хойд талаараа Өмнөговь, Тариалан сумтай хиллэж, хойд ба зүүн өмнө талаараа Увс, Хяргас нуураар хязгаарлагдана. Сумын нутгийн 80% говь, тал хээр эзлэх боловч Хан хөхий нурууны үргэлжлэл Тогтохын шилийн дтд 2000-2300 м өргөгдсөн Хүрмийн овоо, Бор залаа, Хайст, Бугат, Цагаан овоо, Сайн өндөр зэрэг өндөр уулстай. Одоо тус сум 1065 өрхтэй, 4533 хүн амтай, 158532 толгой малтай болж түүхэнд тоолуулаагүй олон малтай болсон нь манай

УВС АЙМГИЙН НАРАНБУЛАГ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХАРГАНАТ”-ЫН ТӨМРИЙН ОРДЫН
ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
малчдын хөдөлмөрийн үр дүн юм. Сумын ИТХ, Засаг дарга, түүний тамгын газар, дунд
сургууль, хүн эмнэлэг, хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв зэрэг төсөвт байгууллагууд,
Банк, Холбоо, ШТС, худалдаа, нийтийн хоолны цэг, салбар зэрэг үйлчилгээний
байгууллагууд, мал аж ахуй, газар тариалан, хувийн мал эмнэлэг, хадгаламж зээлийн
үйлчилгээ, эсгий эсгий үйлдвэрлэл эрхэлдэг 5 хоршоо, аж ахуйн нэгж байгууллагууд
ажиллаж байна.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

